

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/23

Өлгий

**Өндөр тунт А аминдэмийн хуваарь  
батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14.2.3 дахь заалт, Нягтлан бодох тухай бүртгэлийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.21 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/64 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн сангийн Улс орны VII хөтөлбөрийн хүрээнд буцалтгүй тусламжаар нийлүүлсэн 06 сараас 5 хүртэлх насны хүүхдэд “Өндөр тунт А аминдэм түгээх хуваарь”- ийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Хуваарийн дагуу өндөр тунт А аминдэмийг харьяа нутаг дэвсгэрийн 06 сараас 5 хүртэлх насны хүүхдэд халдвар хамгааллын дэглэмийг сахин түгээлт хийж, тайланг Эрүүл мэндийн сайдын 2020 оны 490 дүгээр тушаалын дагуу аймгийн Эрүүл мэндийн газарт ирүүлэхийг сум дундын эмнэлэг, сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, эрхлэгч нарт даалгасугай.

3. Бага насны хүүхдийн дархлааг дэмжих, хоол тэжээлийн дутал, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгааг иргэдийн дунд тасралтгүй зохион байгуулж, мэргэжлийн зөвлөгөө, мэдээллээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн /Т.Рахат/- д даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга /Е.Сауле/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.САКЕН

2023 оны 05 сарын 29 өдрийн 17/23 тоот  
тушаалын ... хавсралт



**Өндөр тунт А аминдэмийг 5 хүртэлх насны хүүхдэд түгээх хуваарь**

№	Сум, өрх	6-11 сартай хүүхэд		12-59 сартай хүүхэд	
		Хүүхдийн тоо	100,000 ОУН	Хүүхдийн тоо	200,000 ОУН
1	Алтай	67	70	501	526
2	Алтанцөгц	45	47	366	384
3	Баяннуур	61	64	578	607
4	Бугат	55	58	549	576
5	Булган	57	60	668	701
6	Буянт	39	41	360	378
7	Дэлүүн	90	94	1010	1060
8	Ногооннуур	98	103	902	947
9	Сагсай	61	64	741	778
10	Толбо	47	49	583	612
11	Улаанхус	94	99	1202	1262
12	Цэнгэл	122	128	1364	1432
13	Цагааннуур	1	1	229	240
14	Хотгор	4	4	79	83
15	Жансая	163	171	1260	1323
16	Мейрим	159	167	1926	2022
17	Рауан	64	67	767	805
18	Шипагер	154	162	1393	1463
19	<b>Нийт</b>	1381	1449	14 478	15 199

Тайлбар:6-11 сартай хүүхдэд 200 000 ОУН А аминдэмийг Эрүүл мэндийн сайдын 2020 оны 490 дүгээр тушаалын дагуу 1/2 капсул (3 дусал)-ыг 100 000 ОУН-ээр тооцон, уулгана.

ХЯНАСАН: НЭМТ-ИЙН ДАРГА *Е. Сауле* Е. САУЛЕ  
ХУВААРЬ ГАРГАСАН: ЭМГ-ЫН ХООЛ ТЭЖЭЭЛ, ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН *Рахат* Т. РАХАТ